

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙН БИЕЧИЛСЭН ХАМГААЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

Н.М. НХБАТ

ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн эрхлэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч, магистр
цахим хаяг: kod.munkhhuu@yahoo.com

Хураангуй

Биечилсэн хамгаалалтын арга хэмжээ нь аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний нэг хэлбэрт ордог. Гэрч, хохирогчийг хамгаалах нь эрхлэлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тэдгээрийн амь нас, эрхлэл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд оршдог. Гэвч эрхлэлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал оролцогч болох гэрч, хохирогчийн амь нас, эрхлэл мэндэд халдах, угсгын мэдээллээс буцаах, ятгах, нөлөөлөл хэрэг тохиолдолууд практикт гардаг.

Заналхийлэгч этгээдийн дээрх үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, биечилсэн болон бусад хэлбэрийн хамгаалалтыг хэрэгжүүлэх зорилгоор эрхлэлийн албан тушаалтаны шийдвэрээр хамгаалалтыг хэрэгжүүлдэг. Улсын хэмжээнд цагдаагийн байгууллагад 2016 онд 33, 2017 онд 22, 2018 онд 51, 2019 онд 144, 2020 онд 104, 2021 онд 232 хамгаалалтыг хэрэгжүүлсэн бөгөөд үүнээс нийт гэрч 37, хохирогч 366, хамаарал бэлхий этгээд 55 хүн хамгаалалтад орсон бөгөөд цаашид угсгын хандлагатай байна. Тиймээс гэрч, хохирогчийн биечилсэн хамгаалалтын арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтад тулгамдаж буй асуудлыг цогц байдлаар авч үзэн түүнийг сайжруулах, боловсронгуй болгох арга замыг шинжлэх ухааны судалгааны үндсэн дээр дэвшүүлэн гаргаж үнэлэлт, дүгнэлт үзэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох нь энэхүү судалгааны ажлын үндэслэл, онол, практик хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг тодорхойлно.

Түлхүүр үгс: Гэрч, хохирогч, биечилсэн хамгаалалт, аюулгүй байдал, эрх бэлхий албан тушаалтан, заналхийлэгч.

Сэдвийн судлагдсан байдал. “Хууль сахиулах удирдлага” болон “Гэмт явдал судлал” чиглэлээр угсгийн жилүүдэд хийгдсэн судалгааны ажлуудад дүн шинжилгээ хийж үзвэл цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, түүнд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам²⁵, цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, сургалт, түүний удирдлагын хэрэгжилтийн талаар²⁶ магистрын түвшинд нилээд судлагдсан байна.

Судалгааны ажлын үр дүн. Судалгааны ажлын үр дүн практикт нэвтрүүлснээр цагдаагийн байгууллага эрхлэлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн аюулгүй байдлыг хангах ажлыг хэрхэн хэрэгжүүлж ирсэн түүхэн уламжлал, шинэчлэлийн нөхцөл байдал, хөгжлийн орнуудын бодлого журамтай харьцуулан судлаж, хуулийн байгууллагуудаас гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулж буй ажлын үнэмлэхүй байдалд үнэлэлт дүгнэлт үзэх, биечилсэн хамгаалалтын арга хэмжээнд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх арга зам, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход шинэлэг байдал, судалгааны ажлын үр дүн, бодит боломж нөхцөл байдлыг үзэж байна.

Монгол Улсын үндсэн хуулийн 19.1 дэх хэсэгт ... Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зорихтэй тэмцэх, хүнд гдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна... 38.2.7 дахь хэсэгт “Засгийн газар ... дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх

²⁵ Гантулга.С. Мөрдөгчийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах. - УБ., 2017, Мягмарсүрэн.Ц. Зам тээврийн осол хэргийн эрсдэлийн удирдлага. - УБ., 2017, Мөнх-Итгэл.Н. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт. - УБ., 2015.

²⁶ Золбаатар.Э. Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн сургалт. - УБ., 2015.

арга хэмжээ авч хэрэгжүүлэх²⁷” гэж тус тус заасан байна.

Уг хуулийн 10 дугаар зүйлийн "Хүний халдашгүй байх эрхийг хангах" тухай заалтаас харахад гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн яллагдагчийн эрх зүйн байдал, шүүгдэгчийн халдашгүй байх эрх"-ийг хамгаалснаас биш хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэх гэрчийг хамгаалах асуудлыг орхигдуулсан байна.²⁸

Үндсэн хуулийн дээрх заалтууд нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нийтлэг байдлыг илэрхийлж байгаа түүнийг тусгайлсан эрх бий болгоход чиглэгдсэн. Түүрхтэй хэлбэл нийгмийн тодорхой харилцааны онцлогтой холбоотойгоор иргэний эдлэх эрхийн үндэс болох юм.

Тэгэхээр үндсэн хуулийн дээрх заалтуудаар Монгол Улсад гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг тусгайлан зохицуулах үндсэн хуулийн үндэслэл буй нь тодорхойлогдож байна.

Одоогоор гэмт хэргийг шалгаж, сэжигтэн, яллагдагчийн гэм бурууг тогтоох мөрдөн шалгах ажиллагааны арга тактик үндсэндээ “мэдүүлгийн арга”-д тулгуурлан хийгдэж байгаа нь тэдний гэм бурууг нотолж байгаа гол эх сурвалж гэрч, хохирогчийн мэдүүлэг болж байна. Түүрхтэй хэлбэл, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримтат мэдээлэл нь үндсэндээ гэрч, хохирогчийн мэдүүлгээр тогтоогдох нөхцөл байдлыг бий болгож байна. Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гэрч, хохирогч голлох үүрэг гүйцэтгэх оролцогч тул тэдний аюулгүй байдлыг хамгаалах асуудал чухал байр суурийг эзлэх болсон.

Үнд үндэслэн гэрч, хохирогчийг хамгаалахыг нэр томъёоны хувьд тайлбарлан авч үзвэл.

Хууль зүйн ухааны докторантур Д.Энх-Амгалан: Гэрч, хохирогчийг хамгаалах гэдэг нь хэрэг явдлыг тодорхойлон батлахад холбогдох ямар нэгэн баримт гаргах этгээд, хохирсон этгээд зэргийг учирч болох элдэв аюул ослоос сэргийлэн, хүнл учруулахгүйн төлөө сахин харгалзахыг хэлнэ²⁹ гэсэн бол Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код: Гэрч, хохирогчийг хамгаалах гэдэг нь гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулаас сэргийлэхийн тулд сахин хамгаалж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэлнэ³⁰ гэсэн бол Бидний бодлоор гэрч, хохирогчийг хамгаалах гэдэг нь бодит болон далд аюул занал, айдас, итгэлгүй байдал, бусад хязгаарлалтаас хамгаалах үйл ажиллагаа бүрдүүрх утгаараа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах баталгааг хэлнэ гэж үзэж байна.

Биечилсэн хамгаалалтын арга хэмжээний тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт

Гэрч, хохирогчийг хамгаалах нь аюулгүй байдлын болон сэтгэл зүйн хамгаалалт гэсэн 2 төрөлтэй. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ нь Урьдчилан сануулах, Тодорхой үйлдлийг хязгаарлах, **Биечилсэн хамгаалалт**, Мэдээллийн нууцлалыг хангах, Нэг бүрийн болон тусгай техник хэрэгсэлээр хангах, Аюулгүй газарт төр байрлуулах, Бичиг баримт солих, Нүүлгэн шилжүүлэх, Гадаад төрхийг үүрчлэх зэрэг 9 төрөлтэй байдаг. Үүнээс биечилсэн хамгаалалт нь хүн, хүч, санхүү, мөнгө шаардсан чухал хамгаалалтын хэлбэр юм.

Үүнээс биечилсэн хамгаалалт гэдэг нь гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй аюулгүй байдлын хамгаалалтын нэг хэлбэрийг хэлдэг.

Гэмт хэргийн бодит байдлыг шалгаж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг нотлоход багагүй хэмжээний саад учруулж байгаа асуудлын нэг нь гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд сүүргүүлэх, заналхийлэх, тэдэнд шан харамж амлах замаар хуулийн хариуцлагаас мултрах гэсэн оролдлого нотлох ажиллагааны явцад түүгээмэл хэлбэрээр бий болж, хэргийн бодит үнэнийг гуйвуулах, яллагдагч этгээдэд ашигтайгаар шийдвэрлэх, түүний гэм бурууг хаацайлах сүүргүүлэх дагавараас хамгаалах, урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэглэдэг.

²⁷ Монгол Улсын үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992 он. №1

²⁸ Оюунчимэг.Т. Гэрч. УБ., 2013 он. 116 дахь тал

²⁸ Энх-Амгалан.Д. (2013). Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал магистрантын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар. Билиг дээд сургууль

³⁰ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ., 2018 он. 511.2 дахь тал



Энэ нээс эвэл цаашид хамгаалалтын тоон мэдээ нх хандлагатай байгаа бггд практикт биечилсэн хамгаалалтад ажиллаж буй алба хаагчийн тоо нрдэгнй, ажлын ачаалалтай байдаг.

Биечилсэн хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтад тулгамдаж буй асуудал

Биечилсэн хамгаалалтын журмын 4 дгээр зйлйин 4.6 дах хэсэгт...нэг биечилсэн хамгаалалтад аюулын зэргийн твшинд ндэслэн 3-5 алба хаагч нрэг гйцэтгэнэ³¹ гэж заасан байдаг. Гэтэл н, нчийн нц хэрэгжлж буй хамгаалалттай харьцуулахад бага байдаг тул алба хаагчийн ажлын ндр твшинтэй бггд багасгахын тулд журамд ндэслэн хэлтсийн орон тоог нэмэх шаардлага зй ёсоор нсэж байна.

Практикт гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бхий этгээд, гэмт хэргийг илрлэхэд туслалцаа злсн н, шаардлагатай тохиолдолд прокурор, шгчийг хамгаалалтад авч байгаа бггд нд хэргийн мрдн шалгах ажиллагаанд оролцож буй шинжээч, орчуулагч, хэлмэрчийг биечилсэн хамгаалалтад авах шаардлага нсэж байна. Учир нь заналхийлэгч этгээдээс шинжээчид нлн хуурамч дгнэлт гаргуулах, орчуулагч, хэлмэрчид нлн худал орчуулж, хэлмэрчлэхээр хууль бус йлдэл явуулж болзошгй тул шаардлагатай тохиолдолд шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хамгаалалтад авч болох талаар эрх зйн орчныг брдлэх хэрэгтэй.

2.1. Гадаад орны эрх зйн зохицуулалтын талаар:

Монгол Улс:

- Гэрч,
- Хохирогч,
- Хамгаарал бүхий этгээд,
- Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн хүн,
- Шаардлагатай тохиолдолд шүүгч, прокурор.

Турк Улс:

- Турк улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд зааснаар хүнд хохирол, хор уршиг учруулсан гэмт хэргийг гэрчилсэн гэрч,
- 10 жилээс дээш хутацаагаар хорих ялтай гэмт хэргийг гэрчилсэн гэрч,
- Зохион байгуулалттай гэмт бүлгийн үйл ажиллагааг гэрчилсэн гэрч,
- Гэрчийн ойр дотно, төрөл, садны хүмүүс.

Оросын Холбооны Улс:

- Хохирогч,
- Гэрч,
- Хүний мөрдөгч,
- Шинжээч, орчуулагч, хэлмэрч
- Иргэний хариуцагч, иргэний нэхэмсэгч, хохирогчийн төлөөлөгч болон хууль ёсны төлөөлөгч гэх мэт.

³¹ <https://www.legalinfo.mn/annex/details/6569?lawid=10750> хандалт 2021.09.23

Энэ нь зөвхөн Оросын холбооны улс шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хамгаалалтад авдаг. Монгол Улсын хувьд гадаад орны туршлагаас судлаж зөрийн орны эрх зүйн онцлогт тохируулан нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Дүгнэлт:

Гэрч, хохирогчийн биечилсэн хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтад тулгамдаж буй асуудлыг цогц байдлаар авч үзэн, улмаар түүнийг сайжруулах, боловсронгуй болгох арга замыг шинжлэх ухааны судалгааны үндсэн дээр дэвшүүлэн гаргаж үнэлэлт, дүгнэлт өгөх нь энэхүү судалгааны ажлын үндэслэл, онол, практик хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг тодорхойлж байгаа хэрэг бөгөөд судалгааны ажлыг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Гэрч, хохирогчийн биечилсэн хамгаалалтаар шүүгчийн захирамж, прокурорын тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар хамгаалалтад авах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ зохион байгуулах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлагаар ханган хэлтэс байгуулагдсанаас хойш биечилсэн хамгаалалтын нийт 54 арга хэмжээ хэрэгжүүлж, гэрч 24, хохирогч 31, хамаарал бүхий этгээд 43, шүүгч 8, прокурор 10, нийт 116 иргэний аюулгүй байдлыг хангаж ажилласан бол биечилсэн хамгаалалтыг хэрэгжүүлсэн дундаж хугацаа 1-2 сар байдаг бол хамгийн ихдээ 2 жил 5 сарын дээрх дурдсан оролцогч, хамгаалуулагч нарыг биечлэн дагаж хамгаалсан байна. Дээрх хамгаалалтыг зохион байгуулахад улсын төсвөөс тодорхой хэмжээний төсвийг тусад нь төсвөлж байх хэрэгцээ шаардлагатай юм.

2. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор Тэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улс орон бүрт уриалсан нь гэрч, хохирогчийг хамгаалах олон улсын эрх зүйн эх сурвалж болсон.

3. Гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, мэдээлэл өгсөн иргэнийг биечилсэн болон бусад хэлбэрийн хамгаалалтад авах, тэдний аюулгүй байдлыг хангах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт үндэсний хэмжээний эрх зүйн орчин талаасаа зохих хэмжээнд бий болсон хэдий ч хуулийн зарим заалтууд хоорондоо зөрчилдөж байна.

4. Хуулийн дагуу биечилсэн хамгаалалтад авагдсан иргэний аюулгүй байдлыг хангах мэргэшсэн нэгж байгуулагдсан боловч санхүүгийн эрхгүй нь хойшлуулшгүй болон шаардлагатай зардлыг цаг алдалгүй, түргэн шуурхай гаргахад хүндрэл учирдаг, 4-5 хамгаалалтыг давхар хэрэгжүүлэхэд хүн, хүч, техник хэрэгслийн дутагдалтай байдалд хүрч улмаар хамгаалуулагчид эрсдэл өгсөх нөхцөл байдал бий болдог, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад энэ чиг үүргийг хэрэгжүүлэх шууд уурэг бүхий ажилтан, алба хаагч байдаггүй зэрэг нь хүндрэлтэй байна.

5. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хүтлэг бүрт түүрийн болон түүрийн бус байгууллагаас авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгасан боловч хэрэгжилт хангалтгүй, төсөв, хүрэнг суудаггүй, нэгдсэн удирдлагаар хангагдахгүй байгаад дүгнэлт хийж, гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий этгээд, мэдээлэл өгсөн иргэнийг биечилсэн болон бусад хэлбэрийн хамгаалалтаар хангах, тэдэнд нийгмийн үйлчилгээ үзүүлэх нэгдмэл системийг бий болгох нэгдсэн удирдлагаар хангах, насанд хүрээгүй хүнийг биечлэн хамгаалах, далд болон орчны хамгаалалт зохион байгуулахад ашиглах журам, стандарт байхгүй байна.

Дэвшүүлсэн санал

Нэг. Эрх зүйн зохицуулалтын талаар:

1. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, биечилсэн болон бусад хэлбэрийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, түүрийн болон түүрийн бус, нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг, оролцоог татаж оролцуулах хэрэгцээ шаардлагад үндэслэн гэрч, хохирогчийг хамгаалах ажлыг уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий улсын хэмжээний Зөвлөлийг Хууль зүйн, дотоод хэргийн сайдын дэргэд байгуулах нь зүйтэй байна. Зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдаж, бүрэлдэхүүнд нь санхүүгийн, хүндэтгэл, нийгэм хамгааллын болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн түүрийн захиргааны төв байгууллага, мөрдөн шалгах ажиллагаа явуулах

чиг өөрөг бөхий байгууллага, прокурор, шүүх, холбогдох бусад байгууллагын төлөөлөл ажиллах ба Зөвлөлийн бэрэлдэхдөө ажиллах журмыг Засгийн газар баталж байхаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байхаар эрх зүйн орчныг бүрдүүлэх.

2. Биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх өөрөг бөхий байгууллагууд, шүүх, прокурор, шүүхээс гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бөхий этгээд, мэдээлэл өгсөн иргэний аюулын эрсдэлийн төвшнийг тогтоох нэгдсэн аргачлал, загвар байхгүй учир эрсдэлийн төвшин нэн бодитой тогтоогдохгүй байх, байгууллага бүр эрсдэлийн төвшнийг харилцан адилгүй тогтоох, үүнээс үүдэн хамгаалуулагчийн амь нас эрүүл мэндэд аюул эрсдэл учрах, гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны шуурхай байх зарчим алдагдахад хүрч болзошгүй. Иймд гэрч, хохирогч, тэдгээрийн хамаарал бөхий этгээд, мэдээлэл өгсөн иргэнийг биечилсэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл болох аюулын эрсдэлийн төвшин тогтоох аргачлалыг шинэчлэн боловсруулж, хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, шийдвэр гаргах эрх бөхий албан тушаалтнууд нэг аргачлал, стандартыг мөрдөх эрх зүйн зохицуулалтын орчныг бий болгох шаардлагатай байна.

Хоёр. Бүтэц, зохион байгуулалтын талаар:

1. Нийслэл хотод гэрч, хохирогчийг хамгаалах хөний нөөц, хүч хэрэгсэл хэрэлцэхгүй байгаа нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд тус хэлтсийн мэдэлд биечилсэн хамгаалалтад өөрөг гүйцэтгэх тодорхой тооны, мэргэжлийн сургалтад суралцуулан чадваржуулсан ахлагч бэрэлдэхдөөнийг ажиллуулан, ажлын ачаалал буурсан үед нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг нөхцөл байдал хүндэрсэн газар, чиглэлд өөрөг гүйцэтгэлдэг хэлбэрээр зохион байгуулах.

2. Орон нутагт гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагаа, биечилсэн болон бусад хэлбэрийн хамгаалалтыг зохион байгуулах чиг өөрөг бөхий мэргэжлийн болон зохион байгуулалтын удирдлагаар хангах ажиллагаа эзэнгүйдэж байгаад дүгнэлт хийж нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэст Гэрч, хохирогчийг хамгаалах тасаг, нэгжийг 5 хүртэлх хөний орон тоотой байгуулан ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэст харьяалуулан үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах.

3. Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчдыг биечилсэн хамгаалалтад мэргэшүүлэх чиглэлээр танхимын сургалтыг зохион байгуулахаас гадна эхний ээлжинд тушаалаар томилогдсон гэрч, хохирогчийг хамгаалах чиг өөрөг хариуцсан алба хаагчдыг 14 хоногийн хугацаанд хэлтэсд цүн тоогоор ээлжлэн ажиллуулж, хамгаалалтын арга хэмжээнд оролцуулж практик дадлага, сургалтыг зохион байгуулах. Ингэснээр орон нутагт биечилсэн хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулахад бэлтгэл ажил хангагдахаас гадна алба хаагчдыг мэргэшэх, чадавхжуулах ач холбогдолтой билээ.

Гурав. Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын талаар:

1. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төрийн бөх байгууллага салбартаа хэрэгжиж байгаа бодлого, хөтөлбөр, төслийг гэрч, хохирогчийг хамгаалах, биечилсэн болон бусад хэлбэрийн хамгаалалтыг зохион байгуулах, туслалцаа үзүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй уялдуулах, төрний биелэлтэд хяналт тавьж ажиллах, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хүрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгуулах ажлыг эрх бөхий албан тушаалтанд хандах, шийдвэрлүүлэх.

2. Гэрч, хохирогчийн биечилсэн хамгаалалтын ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах, хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах, аюулгүй байдал баталгаатай хангагдах эрх зүйн болоод үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтын орчин бий болсныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллээр хангахад чиглэсэн ажлыг төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагаар дамжуулан тасралтгүй хэлбэрээр тогтмол зохион явуулах.

3. Дэлхийн хөгжингүй улс орны гэрч, хохирогчийн биечилсэн хамгаалалтын талаарх эрх зүйн зохицуулалт манай улсад тусгалаа олсон хэдий ч улс орон бүрт үйл ажиллагаандаа ашиглаж буй техник хэрэгслийг сайтар судлан үр дүнтэй нэвтрүүлэх. Тухайлбал Оросын холбооны улсын биечилсэн хамгаалалтын туршлагаас үзэхэд химийн хавх буюу тэмдэглэгээ хийх зориулалттай төхөөрөмжийг ашигладаг байна.

Тухайн тухайн рмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэнээр заналхийлэгч этгээдийн үйл хөдлөлийг хянах, гадны довтлого, аюул, эрсдлээс хамгаалахад чухал үр дүнтэй алхам болох юм.

Ном зүй:

1. Монгол Улсын үндсэн хууль.УБ. 1992 он
2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. УБ. 2014 он
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2017 он
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ. 2018 он
5. Т.Оюунчимэг. Гэрч. УБ. 2013 он
6. Д.Энх-Амгалан. Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал. УБ. 2013 он
7. П.Батбаатар. Гэрч хохирогчийн аюулгүй байдлын онол практикийн асуудал. 2021 он
8. ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн тоон мэдээ. УБ. 2020 он
9. <https://www.legalinfo.mn/annex/details/65697lawid=10750>
10. <https://www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5726.pdf> /Турк улсын хууль /
11. <http://base.garant.ru/12136633/Опосын холбооны улсын хууль/>